БАТЛАВ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Э.БАТТУЛГА

2026 оны 2 дугаар сарын 27

Багц 2. "Төв байрны эрчим хүчний байнгын тасралтгүй үйл ажиллагааг хангах цахилгааны нөөц дизель станц 200 kwa хүчин чадал бүхий цахилгаан станц авч суурилуулах /Улаанбаатар/" төсөл арга хэмжээнд тусгагдсан цахилгаан станц ажлын даалгавар, техникийн тодорхойлолт

1.Ажлын даалгавар

№	Ажлын нэр төрөл	Тайлбар
1.1	Үндэслэл	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4.13 дахь заалт; Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр; Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт код- УТ2601300942-2
1.2.	Ажлын зорилго	1.2.1 Цаг уур, орчны шинжилгээний газрын (цаашид Захиалагч гэх) төв байр болон өргөтгөлийн барилгын цахилгаан хангамжийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор нөөц цахилгаан үүсгүүр (цаашид дизель генератор гэх)-ийн системийг нийлүүлэх, суурилуулах, холбох, ашиглалтад оруулах, холбогдох сургалт зохион байгуулах цогц ажлыг хэрэгжүүлэхэд оршино. 1.2.2 Одоо ашиглагдаж буй хуучин нөөц генераторын найдвартай ажиллагааг хангах, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор шаардлагатай сэлбэг хэрэгслийг солих, иж бүрэн засвар үйлчилгээ, туршилт, тохируулгын ажлыг хийж гүйцэтгэнэ.
1.3.	Байршил	Улаанбаатар хот, Цаг уур, орчны шинжилгээний газар
1.4.	Захиалагч байгууллага	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Цаг уур, орчны шинжилгээний газар
1.5.	Төсөвт өртөг	Нийт төсөвт өртөг 375 сая төгрөг. (НӨАТ багтсан) Худалдан авалт, суурилуулалт, туршилт, засвар, сургалт, бусад шаардлагатай бүх ажлын зардал багтсан.
1.6.	Гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш хуанлиан 60 хоног хүртэл

2. ДИЗЕЛЬ ГЕНЕРАТОРЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Ерөнхий шаардлага: Цахилгаан станц нь тусгай тоноглогдсон (дизель генератор) байна.

2.1.1. Дизель генераторын ерөнхий техникийн үзүүлэлт

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	Шаардлага
1	Төрөл	Дизель хөдөлгүүртэй, автомат удирдлага, алсын зайн хяналтын системтэй, гадна ашиглах зориулалтын бүхээгтэй (кабин) генератор
2	Ажиллах горим	Standby (нөөц тэжээл)
3	Давтамж	50 Гц
4	Хүчдэл	380 / 400 / 415 В
5	Нэрлэсэн чадал	400 кВА-аас доошгүй
6	Эрчим хүчний коэффициент	cosφ = 0.8
7	Ашиглалтын орчин	Монгол орны уур амьсгал, цаг агаарын нөхцөлд тохирсон, байгууллагын үйл ажиллагаанд сөрөг нөлөөгүй, гадаа байрлуулан ашиглах боломжтой

2.1.2. Хөдөлгүүрийн техникийн үзүүлэлт

Хүснэгт 2

№	Үзүүлэлт	Шаардлага
1	Хөдөлгүүрийн загвар	Caterpillar C9.3B эсвэл түүнтэй дүйцэхүйц
2	Хөдөлгүүрийн төрөл	Inline 6, 4-такт дизель
3	Эзлэхүүн	≈ 9.3 литр
4	Агаар соролт	Турбо цэнэглэгчтэй, турбоор шахагдсан агаарыг агаар-агаарын хөргөлтийн систем (air-to-air aftercooler)-ээр хөргөн цилиндрт нийлүүлдэг
5	Түлшний систем	Common Rail электрон удирдлагатай түлш шахалтын систем эсвэл түүнтэй дүйцэх
6	Эргэлтийн удирдлага	Электрон (ADEM A6 түвшинтэй дүйцэх)

2.1.3. Генератор (Alternator)-ын үзүүлэлт

Хүснэгт 3

№	Үзүүлэлт	Шаардлага
1	Alternator Insulatio class	H 160 -180°C ISO9001: 2015
2	Frame size	A2925L41 түвшинтэй дүйцэх
3	Сэргээх систем	S.E (Self-Excited)
4	Температурын өсөлт	≤ 163 °C
5	Мотор асаах чадвар (30% voltage dip)	≥ 830 skVA

2.1.4. Түлшний зарцуулалт (дүйцэхүйц)

Хүснэгт 4

Түлшний зарцуулалт, түлшний сав (дүйцэхүйц)	
75% ачаалалд	≤ 61 л/цаг
50% ачаалалд	≤ 42.5 л/цаг
Түлшний савны багтаамж	529 л

2.1.5. Хөргөлт ба яндангийн систем

Хүснэгт 5

№	Үзүүлэлт	Шаардлага
1	Хөргөлтийн систем	Радиаторын иж бүрэн систем
2	Яндангийн хийн температур	≤ 520 °C
3	Яндангийн эсрэг даралт	≤ 15 kPa
4	Яндан, дулаалга	Суурилуулалтын хүрээнд бүрэн шийдсэн

2.1.6. Бүхээгтэй үеийн хэмжээ, жин (дүйцэхүйц)

Хүснэгт 6

Үзүүлэлт	Утга
Урт	~ 4000 мм-ээс ихгүй
Өргөн	~ 1400 мм-ээс ихгүй
Өндөр	~ 2000 мм-ээс ихгүй
Хуурай жин	~ 2900 кг-аас ихгүй

2.1.7. Цахилгаан үүсгүүрийн хэт ачаалал

Хүснэгт 7

Хэт ачааллах хувь	Ажиллах хугацаа
110%	~ 60 мин-с багагүй
150%	~ 2 мин-с багагүй

2.1.8. Автомат сэлгэн залгах систем (ATS)

Хүснэгт 8

№	Үзүүлэлт	Шаардлага
1	ATS-ийн гүйдэл	250 A
2	Тоо хэмжээ	2 ширхэг
3	Ажиллах горим	Төв тэжээл ба генераторын хооронд бүрэн автомат
4	Аюулгүй ажиллагаа	Механик болон цахилгаан хос блокировкын хамгаалалттай, төв тэжээл ба генераторын тэжээлийг зэрэг холбох боломжгүй, буцах гүйдлээс бүрэн хамгаалсан, хамгаалалтын дохиогоор автоматаар салгах, зогсоох горимтой

2.1.9. Засвар үйлчилгээ, сэлбэг

(ЦУОШГ-ын хуучин CATERPILLAR-ийн генераторт /CAT 135кВА/)

Хүснэгт 9

№	Ажлын нэр	Тоо хэмжээ / Тайлбар
1	Яндан солих	1 иж бүрдэл
2	Мэдрүүр (датчик) солих	Шаардлагатай бүх мэдрүүр
3	Агаарын шүүр	2 ширхэг
4	Тосны шүүр	4 ширхэг
5	Бүрэн үйлчилгээ	Тос, шүүр солих, шалгалт хийх, туршилтаар ажиллуулах, хөдөлгүүрийн тосны дэлгэрэнгүй шижилгээ хийх

3. СУУРИЛУУЛАЛТ, ХОЛБОЛТЫН АЖИЛ

Шинэ болон хуучин генераторт дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:

- ЦУОШГ-ын төв байр болон өргөтгөлийн барилгад батлагдсан цахилгааны схемийн дагуу холбож, ашиглалтад оруулах
- Генераторын гадна аюулгүй хамгаалалтын хашаа барих
- Байгууллагын аюулгүй ажиллагааны гарц, орцыг чөлөөлөх
- Кабель, газардуулга, хамгаалалтын системийг холбогдох стандартын дагуу гүйцэтгэх
- ЦУОШГ-ын хуучин генераторт (хүснэгт 9-д заасан)-г үйлдвэрийн баталгаат бүрэн засвар, үйлчилгээ хийх (Албан ёсны үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага байх, хөдөлгүүрийн тос шинжлэх мэргэжлийн лабораторитой байх)

4. БАРИМТ БИЧИГ, СУРГАЛТ

Нийлүүлэгч нь дараах баримт бичиг, материалыг бүрэн хүлээлгэн өгнө. Үүнд:

- Техникийн паспорт
- Багаж, түлхүүр
- Ашиглалтын болон засвар үйлчилгээний заавар (монгол хэл дээр)
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- Анхааруулах наалт, тэмдэглэгээ
- Захиалагчийн инженер, техникийн ажилтнуудад зориулсан ашиглалтын сургалт

---------- 000----------